



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2021 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН  
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/373/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот  
2022 он

Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх  
аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn  
Аудитын менежер: Г.Гүнжидмаа  
Утас: 261885 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn  
Ахлах аудитор: Р.Цолмон  
Утас: 261740 Цахим хаяг: tsolmonr@audit.gov.mn  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:  
Нью Эстимэйтор Аудит ХХК Захирал Т.Бүжидмаа  
Утас: 95157097, 99993667  
Цахим хаяг: jukhertar@yahoo.com

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт.....	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4-16
3. Аудитын тайлан.....	17
3.1 Ерөнхий зүйл.....	17
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	17
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	18
3.4 Материаллаг байдал.....	18
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	19
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	19
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	20
3.8 Аудитын гол асуудал.....	20
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	21
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	22
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	23
4. Аудитын илрүүлэлт.....	24-26
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	27-30

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
ШУТС	Шинжлэх ухаан технологийн сан
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ  
Ц.БИЛЭГТСАЙХАН ТАНАА

2022.03.15 № 07/599  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Аудитын санал дүгнэлт

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,226,542.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа эсвэл нийтээрээ материаллаг боловч өргөн тархаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 "Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага, бүх орлогыг заавал бүртгэнэ", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14.2.1 "Төрийн байгууллага, албан газрын эд хөрөнгийн эрхийг өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах" гэсэн хуулийн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, тохиолдсон байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг өсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>25,303,118,015.51</b>	<b>106,800,251,914.62</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	<b>9,821,322,268.00</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	<b>9,821,322,268.00</b>
31211	Төрийн сангийн харилцах		7,126,535,253.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	2,694,787,015.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>678,476,521.24</b>	<b>9,568,667,400.15</b>
<b>33610</b>	<b>Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага</b>	<b>678,476,521.24</b>	<b>9,568,667,400.15</b>
33300	Татаас санхүүжилт	178,861,000.00	-
33510	Байгууллагаас авах авлага	499,615,521.24	9,567,275,092.15
33520	Хувь хүмүүсээс авах авлага		1,392,308.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>24,624,641,494.27</b>	<b>87,410,262,246.47</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>22,356,330,965.60</b>	<b>84,806,193,476.75</b>
35110	Тусгай зориулалттай материал	1,972,572,620.14	2,377,999,846.85
35130	Эм боох материал	20,383,758,345.46	82,428,193,629.90
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>2,268,310,528.67</b>	<b>2,604,068,769.72</b>
35410	Бичиг хэргийн материал	3,578,160.00	22,905,765.00
35420	Аж ахуйн материал	419,227,648.65	129,025,262.33
35430	Сэлбэг хэрэгсэл	44,184,197.00	62,772,425.00
35440	Түлш, шатах тослох материал	12,235,000.00	16,796,331.00
35460	Хүнсний материал	51,230,812.00	19,040,236.00
35470	Бусад хангамжийн материал	1,737,854,711.02	2,353,528,750.39
	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>44,365,144,194.83</b>	<b>50,370,337,684.17</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>44,365,144,194.83</b>	<b>50,370,337,684.17</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>41,676,332,514.83</b>	<b>47,667,659,799.74</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	36,368,655,921.94	37,859,043,845.94
39202	Хуримтлагдсан элэгдэл	(2,292,758,040.53)	(3,438,363,660.55)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,214,902,098.00	1,328,202,098.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(952,885,875.51)	(1,016,088,961.40)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	15,679,100,141.78	22,113,677,882.79
39206	Хуримтлагдсан элэгдэл	(9,014,869,686.54)	(10,169,957,985.75)

39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,420,745,171.21	1,832,731,194.34
39208	Хуримтлагдсан элэгдэл	(802,914,459.14)	(892,381,876.25)
39209	Зам, гүүрийн байгууламж	67,477,309.47	67,477,309.47
39210	Хуримтлагдсан элэгдэл	(11,120,065.85)	(16,680,046.85)
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>2,688,811,680.00</b>	<b>2,702,677,884.43</b>
39301	Програм хангамж	7,126,000.00	24,196,730.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(5,401,000.00)	(8,605,525.57)
39303	Бусад биет бус хөрөнгө / газар	2,687,086,680.00	2,687,086,680.00
	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>69,668,262,210.34</b>	<b>157,170,589,598.79</b>
	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>668,994,229.94</b>	<b>4,117,286,270.31</b>
	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>668,994,229.94</b>	<b>4,117,286,270.31</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>668,994,229.94</b>	<b>4,117,286,270.31</b>
<b>41330</b>	Татаас санхүүжилт, шижүүлгийн өглөг	119,977,750.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	2,698,013.00	3,701,473,557.93
41364	НДШ-ийн өглөг	546,318,466.94	368,855,352.38
	Хувь хүмүүст өгөх өглөг		46,957,360.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>68,999,267,980.40</b>	<b>153,053,303,328.48</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>20,296,448,769.60</b>	<b>20,296,448,769.60</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	20,296,448,769.60	20,296,448,769.60
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>14,613,066,126.24</b>	<b>98,668,593,128.12</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,822,963,873.46	14,614,557,780.04
51220	Тайлант үеийн үр дүн	12,790,102,252.78	84,054,035,348.08
<b>51300</b>	<b>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</b>	<b>34,089,753,084.56</b>	<b>34,088,261,430.76</b>
	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>69,668,262,210.34</b>	<b>157,170,589,598.79</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>72,837,617,956.21</b>	<b>366,794,621,242.43</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>39,202,197,974.74</b>	<b>299,468,231,117.20</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>39,202,197,974.74</b>	<b>299,468,231,117.20</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>39,202,197,974.74</b>	<b>291,296,384,155.88</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	634,265,078.40	3,349,517,207.81
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,001,337.74	89,243,303.81
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос/ өндөр өртөгт	50,060,279.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-ҮХ	4,017,139,823.08	6,804,564,330.57
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-БМ	34,480,731,456.52	1,185,337,630.75
120045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	287,857,623,644.26
120005	Түрээсийн орлого	-	3,084,000.00
120009	Бусад орлого	-	178,861,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>33,635,419,981.47</b>	<b>67,326,390,125.23</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>24,299,829,700.00</b>	<b>-</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	24,299,829,700.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>8,472,771,004.47</b>	<b>22,434,712,912.89</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,555,693,725.40	2,210,951,957.05
131103	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	-	460,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,994,890,985.47	19,566,525,789.84
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	922,186,293.60	197,235,166.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	<b>-</b>	<b>700,000,000.00</b>



133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	-	700,000,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>862,819,277.00</b>	<b>44,191,677,212.34</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	862,819,277.00	44,191,677,212.34
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>36,331,380,470.27</b>	<b>55,152,491,541.55</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>36,331,380,470.27</b>	<b>55,152,491,541.55</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>33,814,399,027.27</b>	<b>53,848,068,791.55</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>16,945,858,352.34</b>	<b>21,795,051,990.56</b>
210101	Үндсэн цалин	14,116,277,356.34	18,860,406,312.56
210102	Нэмэгдэл	778,757,759.00	695,481,559.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	791,310,000.00	811,211,500.00
210104	Урамшуулал	1,259,513,237.00	1,427,952,619.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>2,246,435,337.64</b>	<b>3,015,065,152.19</b>
210201	Тэтгэврийн даатгал	1,434,146,008.06	2,024,165,821.92
210202	Тэтгэмжийн даатгал	168,723,061.36	216,934,008.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	293,353,853.55	317,041,157.53
210204	Ажилгүйдлийн даатгал	31,807,065.33	41,519,175.14
210205	Эрүүл мэндийн даатгал	318,405,349.34	415,404,989.44
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>1,009,673,660.33</b>	<b>1,315,806,030.37</b>
210301	Гэрэл, цахилгаан	396,612,418.00	521,037,867.00
210302	Түлш, халаалт	349,083,256.55	422,407,403.01
210303	Цэвэр, бохир ус	263,977,985.78	372,360,760.36
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,392,937,958.95</b>	<b>1,159,341,226.13</b>
210401	Бичиг хэрэг	170,048,571.60	96,958,202.00
210402	Тээвэр, шатахуун	371,886,880.00	471,697,619.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	57,346,446.76	98,463,163.87
210404	Ном, хэвлэл	-	1,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	57,029,525.95	76,708,403.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	736,626,534.64	414,513,838.26
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>8,280,881,346.33</b>	<b>21,246,689,995.43</b>



210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,484,717,242.33	20,220,445,191.43
210502	Хоол, хүнс	796,164,104.00	1,026,244,804.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>360,602,209.70</b>	<b>575,563,012.16</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	25,551,950.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,866,500.00	-
210604	Урсгал засвар	353,735,709.70	550,011,062.16
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>370,889,900.00</b>	<b>250,916,200.00</b>
210701	Гадаад албан томилолт	-	-
210702	Дотоод албан томилолт	370,889,900.00	250,916,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>962,246,592.00</b>	<b>1,743,232,269.12</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	948,276,812.00	1,718,975,097.12
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	14,400,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,339,440.00	7,024,955.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,099,740.00	1,971,717.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	129,400.00	860,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,029,600.00	-
210807	Газрын төлбөр	8,371,600.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,244,873,669.98</b>	<b>2,746,402,915.59</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	60,111,000.00	2,114,137.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,184,762,669.98	2,744,288,778.59
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,516,981,443.00</b>	<b>1,304,422,750.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,291,862,330.00</b>	<b>1,304,422,750.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулал	-	1,141,022,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	797,326,168.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшил	1,494,536,162.00	163,400,750.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>225,119,113.00</b>	-
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	225,119,113.00	-
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>36,506,237,485.94</b>	<b>311,642,129,700.88</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>23,716,135,233.16</b>	<b>227,588,094,352.80</b>

225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	8,390,948.75	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	23,707,744,284.41	227,588,094,352.80
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>12,790,102,252.78</b>	<b>84,054,035,348.08</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>34,459,724,426.61</b>	<b>61,242,150,621.70</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>704,326,695.14</b>	<b>3,599,158,469.81</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>704,326,695.14</b>	<b>3,599,158,469.81</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>704,326,695.14</b>	<b>3,417,213,469.81</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	634,265,078.40	3,339,691,207.81
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,001,337.74	77,522,262.00
120005	Түрээсийн орлого	-	3,084,000.00
120009	Бусад орлого	-	178,861,000.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих /өндөр өртөгт	50,060,279.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>33,755,397,731.47</b>	<b>57,642,992,151.89</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>24,299,829,700.00</b>	<b>-</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	24,299,829,700.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>8,472,771,004.47</b>	<b>23,126,814,782.89</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,555,693,725.40	2,203,053,827.05
131103	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	-	460,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,994,890,985.47	19,566,525,789.84
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	922,186,296.60	197,235,166.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	-	700,000,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>982,797,027.00</b>	<b>34,516,177,369.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	925,010,683.00	34,516,177,369.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас /өндөр өртөгт/	57,786,344.00	
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН</b>	<b>34,459,724,426.61</b>	<b>51,080,646,576.70</b>

	ДҮН		
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>34,459,724,426.61</b>	<b>50,471,945,416.70</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>31,942,742,983.61</b>	<b>49,167,936,038.70</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>16,537,626,570.85</b>	<b>22,267,843,375.41</b>
210101	Үндсэн цалин	6,535,874,025.00	6,779,006,159.00
210102	Нэмэглэл	7,783,238,745.85	12,097,201,754.81
210103	Унаа хоолны хөнгөлөлт	863,900,000.00	763,756,097.60
210104	Урамшуулал	1,354,613,800.00	2,627,879,364.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>2,108,934,021.67</b>	<b>2,687,698,854.62</b>
210201	Тэтгэврийн даатгал	1,472,328,021.67	1,810,494,467.62
210202	Тэтгэмжийн даатгал	127,321,200.00	141,425,418.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	229,178,200.00	246,077,475.00
210204	Ажилгүйдлийн даатгал	25,464,200.00	44,796,172.00
210205	Эрүүл мэндийн даатгал	254,642,400.00	444,905,322.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>1,009,673,660.33</b>	<b>1,315,806,030.37</b>
210301	Гэрэл, цахилгаан	396,612,418.00	521,037,867.00
210302	Түлш, халаалт	349,083,256.55	422,407,403.01
210303	Цэвэр, бохир ус	263,977,985.78	372,360,760.36
210304	Байрны түрээс	-	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>751,356,659.76</b>	<b>961,727,803.87</b>
210401	Бичиг хэрэг	140,057,633.00	100,841,758.00
210402	Тээвэр, шатахуун	383,095,380.00	476,258,950.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	57,178,046.76	95,949,847.87
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	137,056,000.00	83,835,045.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	33,969,600.00	203,842,203.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>9,378,058,764.00</b>	<b>19,361,550,296.03</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8,477,564,764.00	18,451,364,789.03
210502	Хоол, хүнс	817,046,900.00	897,070,307.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	83,447,100.00	13,115,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>537,709,342.00</b>	<b>551,635,418.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	148,562,182.00	123,210,465.00
210602	Тавилга		37,118,454.00

210604	Урсгал засвар	389,147,160.00	391,306,499.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>370,889,900.00</b>	<b>263,606,200.00</b>
210702	Дотоод албан томилолт	370,889,900.00	263,606,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,044,548,182.00</b>	<b>1,755,953,923.40</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,003,238,762.00	1,729,852,301.40
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		14,220,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,824,280.00	7,024,955.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,099,740.00	1,971,717.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	58,000.00	860,500.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	1,029,600.00	-
210807	Газрын төлбөр	8,371,600.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	27,926,200.00	2,024,450.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>203,945,883.00</b>	<b>2,114,137.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	203,945,883.00	2,114,137.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,516,981,443.00</b>	<b>1,304,009,378.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,291,862,330.00</b>	<b>1,304,009,378.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	1,141,022,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	797,326,168.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	1,494,536,162.00	162,987,378.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>225,119,113.00</b>	<b>-</b>
	Төвлөрүүлэх шилжүүлэг	225,119,113.00	-
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>-</b>	<b>10,770,205,205.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>-</b>	<b>948,882,937.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>948,882,937.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	-	948,882,937.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-</b>	<b>( 948,882,937.00 )</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>-</b>	<b>9,821,322,268.00</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл / үндсэн	-	7,126,535,253.00

10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл / нэмэлт	-	2,694,787,015.00
11	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	<b>9,821,322,268.00</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	20,296,448,769.60	34,177,147,571.03	1,822,963,873.46	<b>56,296,560,214.09</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт		(87,394,486.47)		<b>(87,394,486.47)</b>
Тайлант үеийн үр дүн / цэвэр ашиг алдагдал /			12,790,102,252.78	<b>12,790,102,252.78</b>
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>20,296,448,769.60</b>	<b>34,089,753,084.56</b>	<b>14,613,066,126.24</b>	<b>68,999,267,980.40</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	1,491,653.80	<b>1,491,653.80</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>20,296,448,769.60</b>	<b>34,089,753,084.56</b>	<b>14,614,557,780.04</b>	<b>69,000,759,634.20</b>
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	(1,491,653.80)	-	<b>(1,491,653.80)</b>
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн / цэвэр ашиг алдагдал /	-	-	84,054,035,348.08	<b>84,054,035,348.08</b>
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>20,296,448,769.60</b>	<b>34,088,261,430.76</b>	<b>98,668,593,128.12</b>	<b>153,053,303,328.48</b>



## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/төгрөгөөр/	
			Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>42,876,869,500.00</b>	<b>39,172,740,054.81</b>	<b>3,704,129,445.19</b>	<b>91.4</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>42,876,869,500.00</b>	<b>39,172,740,054.81</b>	<b>3,704,129,445.19</b>	<b>91.4</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>41,861,350,000.00</b>	<b>39,153,052,676.81</b>	<b>2,708,297,323.19</b>	<b>93.5</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>21,344,779,600.00</b>	<b>19,309,931,264.05</b>	<b>2,034,848,335.95</b>	<b>90.5</b>
Үндсэн цалин	7,150,131,200.00	6,778,719,159.00	371,412,041.00	94.8
Нэмэгдэл	11,725,511,600.00	9,537,028,358.45	2,188,483,241.55	81.3
Унаа хоолны хөнгөлөлт	980,503,300.00	763,756,097.60	216,747,202.40	77.9
Урамшуулал	1,488,633,500.00	2,230,427,649.00	(741,794,149.00)	149.8
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>2,886,989,600.00</b>	<b>2,643,198,398.99</b>	<b>243,791,201.01</b>	<b>91.6</b>
Тэтгэврийн даатгал	1,955,554,000.00	1,765,994,011.99	189,559,988.01	90.3
Тэтгэмжийн даатгал	205,848,100.00	141,425,418.00	64,422,682.00	68.7
ҮОМШӨ-ний даатгал	272,722,400.00	246,077,475.00	26,644,925.00	90.2
Ажилгүйдлийн даатгал	41,169,500.00	44,796,172.00	(3,626,672.00)	108.8
Эрүүл мэндийн даатгал	411,695,600.00	444,905,322.00	(33,209,722.00)	108.1
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>1,322,822,900.00</b>	<b>1,315,806,030.37</b>	<b>7,016,869.63</b>	<b>99.5</b>
Гэрэл, цахилгаан	523,948,000.00	521,037,867.00	2,910,133.00	99.4
Түлш, халаалт	448,087,500.00	422,407,403.01	25,680,096.99	94.3
Цэвэр, бохир ус	350,787,400.00	372,360,760.36	(21,573,360.36)	106.1
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>426,520,600.00</b>	<b>522,778,983.87</b>	<b>(96,258,383.87)</b>	<b>122.6</b>
Бичиг хэрэг	47,856,400.00	51,846,768.00	(3,990,368.00)	108.3
Тээвэр, шатахуун	145,258,000.00	165,002,200.00	(19,744,200.00)	113.6
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30,426,800.00	18,452,267.87	11,974,532.13	60.6
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	128,329,800.00	83,835,045.00	44,494,755.00	65.3
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	74,649,600.00	203,642,703.00	(128,993,103.00)	272.8
<b>Нормативт зардал</b>	<b>13,908,320,300.00</b>	<b>13,368,323,390.53</b>	<b>539,996,909.47</b>	<b>96.1</b>
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,667,628,800.00	12,581,836,878.53	85,791,921.47	99.3
Хоол, хүнс	761,954,400.00	773,371,312.00	(11,416,912.00)	101.5
Нормын хувцас, зөөлөн эдлэл	478,737,100.00	13,115,200.00	465,621,900.00	2.7
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,351,461,400.00</b>	<b>1,159,726,901.00</b>	<b>191,734,499.00</b>	<b>85.8</b>
Багаж, техник, хэрэгсэл	703,911,800.00	237,811,565.00	466,100,235.00	33.8
Урсгал засвар	647,549,600.00	921,915,336.00	(274,365,736.00)	142.4
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>9,920,000.00</b>	<b>586,500.00</b>	<b>9,333,500.00</b>	<b>5.9</b>
Дотоод албан томилолт	9,920,000.00	586,500.00	9,333,500.00	5.9
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>610,535,600.00</b>	<b>832,701,208.00</b>	<b>(222,165,608.00)</b>	<b>136.4</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	438,748,300.00	806,599,586.00	(367,851,286.00)	183.8

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	14,300,000.00	14,220,000.00	80,000.00	99.4
Даатгалын үйлчилгээ	6,179,900.00	7,024,955.00	(845,055.00)	113.7
Тээврийн хэрэгслийн татвар	2,775,400.00	1,971,717.00	803,683.00	71.0
Тээврийн хэрэгслийн оношилгоо	648,000.00	860,500.00	(212,500.00)	132.8
Газрын төлбөр	106,371,600.00	0.00	106,371,600.00	
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	41,512,400.00	2,024,450.00	39,487,950.00	4.9
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,015,519,500.00</b>	<b>19,687,378.00</b>	<b>995,832,122.00</b>	<b>1.9</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,015,519,500.00</b>	<b>19,687,378.00</b>	<b>995,832,122.00</b>	<b>1.9</b>
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,015,519,500.00	19,687,378.00	995,832,122.00	1.9
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>42,876,869,500.00</b>	<b>46,299,275,307.81</b>	<b>(3,422,405,807.81)</b>	<b>108.0</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>19,769,541,100.00</b>	<b>7,048,000,000.00</b>	<b>12,721,541,100.00</b>	<b>35.7</b>
Улсын төсвөөс санхүүжих	19,769,541,100.00		19,769,541,100.00	
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		7,048,000,000.00	(7,048,000,000.00)	
<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>22,722,311,000.00</b>	<b>35,676,177,369.00</b>	<b>(12,953,866,369.00)</b>	<b>157.0</b>
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	22,722,311,000.00	35,676,177,369.00	(12,953,866,369.00)	157.0
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>385,017,400.00</b>	<b>3,575,097,938.81</b>	<b>(3,190,080,538.81)</b>	<b>928.6</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	376,257,300.00	3,459,425,325.81	(3,083,168,025.81)	919.4
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,760,100.00	115,672,613.00	(106,912,513.00)	1320.4
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>0.00</b>	<b>0.00</b>	
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>7,126,535,253.00</b>	<b>(7,126,535,253.00)</b>	
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>749.00</b>	<b>749.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
Удирдах ажилтан	7.00	7.00	0.00	100.0
Гүйцэтгэх ажилтан	496.00	496.00	0.00	100.0
Үйлчлэх ажилтан	246.00	246.00	0.00	100.0

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал, аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгө, төсвийн төлөвлөлт, зарцуулалт болон дотоод хяналттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 17-ноос 2022 оны 03 дугаар сарын 10-ны хооронд Нью эстимэйтор Аудит ХХК-ийн ахлах аудитор Ж.Үхэртар, аудитор Б.Халиунаа, Б.Алтанцэцэг нар гүйцэтгэж, хяналтыг захирал Т.Бүжидмаа хэрэгжүүлсэн.

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 03/215 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Халдварт өвчин судлалын үндэсний төв нь халдварт өвчний хяналт, урьдчилан сэргийлэлт, тандалт судалгаа, оношилгоо, эмчилгээний асуудлыг үндэсний хэмжээнд удирдан зохион байгуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах үүрэг бүхий тусгай мэргэжлийн төв байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 03 дугаар тогтоол
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 05 дугаар тогтоол
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзэв.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС-д нийцсэн боловч байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна. Бодлогын баримт бичигт байгууллагын ЭМДС-ийн санхүүжилтээс үүссэн зөрүү болон орлогын бүртгэл, бараа материалын зайлшгүй байх нөөц, дотоод хяналтын талаар нарийвчлан тусгаагүй байна.

Эрүүл мэндийн яамны хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас тайлант онд үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн боловч дүгнэлт нь гараагүй байна. Тус төвийн бүтэц зохион байгуулалтад хяналт-шинжилгээ, дотоод аудитын албатай байна гэж заасан хэдий ч тайлант онд тус албанд томилогдсон орон тооны ажилтангүй, үйл ажиллагаа явуулаагүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл их гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 72,837,617.9 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 364,188.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 60 хувиар буюу 218,512.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 88,502,327.4 мянган төгрөгөөр буюу 125.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	9,821,322.2	9,821,322.2
Авлага	678,476.5	9,568,667.4	8,890,190.9
Бараа материал	24,624,641.5	87,410,262.3	62,785,620.8
Үндсэн хөрөнгө	44,365,144.2	50,370,337.7	6,005,193.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>69,668,262.2</b>	<b>157,170,589.6</b>	<b>88,502,327.4</b>
Өр төлбөр	668,994.2	4,117,286.3	3,448,292.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	68,999,268.0	153,053,303.3	84,054,035.3
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>69,668,262.2</b>	<b>157,170,589.6</b>	<b>88,502,327.4</b>

Дансны үлдэгдэлд материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 9,821,322.2 мянган төгрөгөөр өссөн нь гүйцэтгэлээр санхүүждэг болсонтой холбоотойгоор дансны үлдэгдлийг төвлөрүүлээгүйтэй холбоотой байна. Тухайлбал: Ковид 19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний эмийн зардал, халдварын төрөл, вакцины үр нөлөө, дархлааны хамгаалах идэвхийг судлах судалгааны ажил, омикрон хувилбарыг илрүүлэхэд шаардлагатай санхүүжилтэнд тус тус зориулан ЭМЯ-наас санхүүжүүлсэн 9,341,832.9 мянган төгрөг, Шинжлэх ухаан технологийн сангийн төслийн санхүүжилтийн 105,000.0 мянган төгрөг болон Гашуун сухайтын боомтын шинжилгээний орлогууд;
- Авлага дансны үлдэгдэл 9,568,667.4 мянган төгрөг болж, 8,890,190.9 мянган төгрөгөөр өссөн Эрүүл мэндийн даатгалын сангаас авах 9,555,554.0 мянган төгрөгийг авлагаар бүртгэснээс шалтгаалжээ. Авлага дансанд удаан жилийн насжилттай, тооцоо нийлээгүй 500.1 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй;
- Бараа материалын данс 87,410,262.3 мянган төгрөг болж, 62,785,620.8 мянган төгрөгөөр өссөн нь Ковид 19 цар тахлын улмаас үнэ төлбөргүй хүлээж авсан эм, эмнэлгийн хэрэгсэл болон бусад бараа материалын орлоготой холбоотой байна. Тайлант онд бараа материалын данс төрийн болон төрийн өмчит бус нийт 108 байгууллагын 288,842,840.9 мянган төгрөгийн үнэ төлбөргүй, 23,299,021.4 мянган төгрөгийн худалдан авсан бараа материалиар тус тус нэмэгдсэн бөгөөд үнэ төлбөргүй хүлээж авсан бараа материалаас 227,425,315.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна. Үнэ төлбөргүй хүлээж бараа материалын 265,085,754.5 мянган төгрөг буюу 91.7 хувийг вакцин түүний дагалдах хэрэгсэл эзэлж байгаа бөгөөд үүнээс 201,782,337.4 мянган төгрөгийн вакциныг зарцуулсан;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 50,370,337.7 мянган төгрөг болж 6,005,193.5 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээж авсан болон худалдан авсан хөрөнгөнөөс шалтгаалжээ. Тайлант онд үндсэн хөрөнгө нь төрийн болон төрийн өмчит бус нийт 99 байгууллагаас үнэ төлбөргүй хүлээж авсан 7,004,684.7 мянган төгрөгийн, худалдан авалтаар 1,907,576.1 мянган төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдсэн.

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 293,957,003.3 мянган төгрөгөөр буюу 403.6 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн үйл ажиллагааны орлого болон үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө болон Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийн орлогууд байна.

Энэ нь Ковид 19 цар тахлын улмаас тайлант онд төрийн болон төрийн өмчит бус нийт 117 байгууллагаас үнэ төлбөргүйгээр 295,847,525.6 мянган төгрөгийн хөрөнгө бараа материал, ЭМЯ болон Эрүүл мэндийн хөгжлийн төв, ШУТС, ЭМДЕГ-аас нийт 19,566,525.8 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 44,191,677.2 мянган төгрөгийн санхүүжилтийн орлогыг тус тус бүртгэснээс шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 222,693,070.2 мянган төгрөгөөр буюу 370.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин шимтгэл, байр ашиглалт, нормативт зардал, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, элэгдлийн зардал болон ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшууллын зардлын дансууд байна.

Цалин хөлс нэмэгдэл урамшил, шимтгэлийн зардал өмнөх оноос 5,617,823.5 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 306,132.4 мянган, нормативт

зардал 12,965,808.6 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 780,685.7 мянган, элэгдлийн зардал 559,526.1 мянган, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшууллын зардал 1,141,022.0 мянган төгрөгөөр тус тус өссөн байна. Энэ нь тайлант онд Ковид 19 цар тахал өргөн тархсанаас шалтгаалжээ.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 21,415,968.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж төсвийг 21,415,968.0 мянган төгрөгөөр баталсан байна. ЭМДҮЗ-ийн 2021 оны 1 дүгээр сарын 22-ны 3-р тогтоолын дагуу эрүүл мэндийн байгууллагууд гүйцэтгэлээр санхүүждэг болсонтой холбоотойгоор ЭМС тайлант оны 12 сард төсөвт тодотгол хийн 42,876,869.5 мянган төгрөгөөр баталжээ.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Халдварт өвчин судлалын үндэсний төв Эрүүл мэндийн даатгалын сангаас 35,676,177.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлого 3,459,425.3 мянга, туслах үйл ажиллагааны орлого 115,672.6 мянга, дээд шатны байгууллагаас 7,048,000.0 мянга, нийт 46,299,275.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 39,172,740.1 мянган төгрөгийг зарцуулж дансанд 7,126,535.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 39,172,740.1 мянган төгрөг буюу 91.4 хувьтай байгаа нь цалин шимтгэл, нормативт зардал, эд хогшлын зардлыг дутуу зарцуулсантай холбоотой байна. Батлагдсан төсвөөс хангамж бараа материал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал болон урсгал засварын зардлыг тус тус хэтрүүлэн зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас авсан судалгааг нэгтгэн дүгнэхэд анхаарал татах асуудал байгаагүй болно.

Халдварт өвчин судлалын үндэсний төв нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг ирүүлээгүй байна.

Ковид 19 цар тахал өргөн тархсаны улмаас тус төв нь тайлант онд насанд хүрэгчдийн гепатитын тасаг болон сүрьеэгийн тасгууд хэвтэн эмчлүүлэх иргэдийг хүлээн авч бусад тасгуудад зөвхөн ковидоор өвчилсөн иргэдийг хэвтүүлэн эмчилсэн байна. Тайлант онд Халдварт өвчин судлалын үндэсний төвд коронавируст халдварын улмаас 9253 иргэн хэвтэн эмчлүүлсэн бөгөөд үүний дотор хөнгөн 1454, хүндэвтэр 5342, хүнд 2196, маш хүнд 261 хүн тус тус хэвтэн эмчлүүлжээ.

### **3.8 Аудитын гол асуудал**

- ЭМС-ын 2021 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн А/02 дугаар бүхий эрх шилжүүлэх тушаалаар тус төвд түргэвчилсэн оношлуур худалдан авахад зориулж 3,957,994.0



мянган төгрөгийг хуваарилснаас 1,633,500.0 мянган төгрөгийн худалдан авалтыг ЭМЯ зохион байгуулсан байна.

- Эрүүл мэндийн байгууллагуудын худалдан авч байгаа эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн тендерийн үнэ ямар эх сурвалжийг үндэслэн тогтоож байгаа нь тодорхойгүй, зөвхөн нийлүүлэгч байгууллагуудаас ирүүлсэн үнийн саналаар зохион байгуулж байна. Иймд эм, эмийн хэрэгслийн үнийг дотоодод үйлдвэрлэсэн болон импортоор гэж ялган, эмийн дундаж үнийг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар тогтоож эрүүл мэндийн байгууллагууд баримтлан худалдан авалтыг зохион байгуулж байх шаардлагатай байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Халдварт өвчин судлалын үндэсний төв нь 2021 онд нийт 98,784,080.7 мянган төгрөгийн 1077 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 3,831,947.3 мянган төгрөгийн 25 гүйлгээг байршуулаагүй, 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, мэдээлбэл зохих 38 худалдан авалтыг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх”, 4.1.1-т “мэдээлэл, үнэн зөв, бодитой иж бүрэн байх”, 6.4.3-т “тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан тул хариуцлага тооцох албан шаардлага өгөх.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

- ЭМС-ын 2021 оны 5 дугаар сарын 12-ны А/307, 6 дугаар сарын 8-ны А/358, 7 дугаар сарын 26-ны А/495 дугаар тушаалуудаар 101,096.0 мянган төгрөгийн Starmag 96 printer C plate ялгах оношлуур, эм, эмийн хэрэгслийг ХӨСҮТ хүлээн авсанаар ЭМЯ-тай тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан хэдий ч санхүүгийн тайланд тусгаагүй, дээрх бараа материалыг зарцуулсан анхан шатны баримтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага, бүх орлогыг заавал бүртгэнэ” гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хуулийн байгууллагад шилжүүлэх.



- Тайлант онд бараа, ажил үйлчилгээ худалдан авсан 54 харилцагчийн 1,307,491.7 мянган төгрөгийн худалдан авалтын цахим төлбөрийн баримтыг аваагүй, цахим төлбөрийн баримтын системд баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэсэн заалттай нийцээгүй тохиолдсон байх ба эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалтын ажил гүйлгээний төлбөрийн цахим баримтыг бэлтгэн нийлүүлэгчээс бүрэн гаргуулан авах, татварын цахим системээр худалдан авалтыг тухай бүр хянаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх, албан шаардлага өгөх.

- Хөрөнгийн тооллогын бүртгэлийг тооллогын комисс бүрэн баталгаажуулаагүй, илтгэх хуудас бэлтгээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.4-т “Комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх” үүрэгтэй гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгийн тооллогын үр дүнг комиссын хурлаар хэлэлцэн баталгаажуулдаг байх талаар зөвлөмж өгөх.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 66,495,513.0 мянган төгрөгийн 12 алдаа зөрчил илрүүлж зөвлөмж өгсөнөөс жилийн эцсийн аудитаар дахин хянахад дараах байдалтай байна. Үүнд: 51,649,039.8 мянган төгрөгийн 5 зөвлөмжийг хэрэгжүүлж, 14,846,473.2 мянган төгрөгийн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй тул аудитын илрүүлэлтэд тусгав.

Өмнөх оны аудитаар 2 зөвлөмж, 4 албан шаардлага өгснөөс нэмэгдэл цалин хөлс, авлага өглөгийн данс, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллахтай холбоотой нийт 3 албан шаардлага 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

*Хүснэгт 3.* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилт:

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	4	2,384,800.4	1	960,420.1	3	1,424,380.3	40.3
Зөвлөмж	2	1,607,511.4	1	618,714.7	1	988,796.7	38.5
Нийт дүн	6	3,992,311.8	2	1,579,134.8	4	2,413,177.0	39.4

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах тухай болон төсвийг зохистой удирдаж, өр, авлага үүсгэхгүй байх талаар өгсөн албан шаардлагын зөрчлийг тайлант онд давтан гаргасан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Халдварт өвчин судлалын үндэсний төвд 2021 оны 12 дугаар сард ЭМЯ-наас Ковид-19 цар тахлын төрөл, вакцины үр нөлөө, дархлааны хамгаалах идэвхийг судлах судалгааны ажлын зардлыг санхүүжүүлэхээр 2,151,800.0 мянган, урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний эмийн санхүүжилтэд 7,048,000.0 мянган төгрөг, нийт 9,199,800.0 мянган төгрөгийг тус тус шилжүүлсэн.
- Тайлант онд шинэ болон дахин сэргэж буй халдварын тасаг, гэдэсний халдварын тасаг, сүрьеэгийн тандалт судалгааны албаны дээврийн их засвар, хоол үйлдвэрлэлийн тасгийн иж бүрэн их засвар, амбулаторийн тасгийн хүлээлгийн танхимын их засвар, уушгины 1 дүгээр тасгийн барилгын их засвар, ариутгал халдваргүйжүүлэлтийн барилгын их засвар болон тусгай зориулалттай лифт суурилуулах үйлчилгээ, мөн цахим бүртгэл мэдээллийн систем болон хиймэл оюун ухаан нэвтрүүлэх системийн хөгжүүлэлт түүнд шаардлагатай мэдээллийн тоног төхөөрөмж, компьютер худалдан авах тендерүүдийг зарлаж хөрөнгө оруулалтыг ЭМЯ болон Засгийн газрын нөөц хөрөнгөөс санхүүжүүлсэн байна. Тус хөрөнгө оруулалтыг бүртгэж авахтай холбоотой тушаал шийдвэр гараагүй, зарим гэрээ бүрэн хэрэгжиж дуусаагүй байна. Иймд дээрх 2 асуудлыг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,226,542.6 мянган төгрөгийн 8 алдаа, зөрчил илэрснээс, 563,881.5 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 1,662,661.1 мянган төгрөгийн алдаа зөрчилд 5 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 8 алдаа, зөрчлийн дүн 2,226,542.6 мянган төгрөг нь тогтоосон материаллаг байдал 218,512.8 мянган төгрөгөөс хэтэрсэн тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

##### 4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайлангийн аудитаар залруулга хийгдээгүй болно.

##### 4.2 Албан шаардлага

1.Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуульд заасан цаглабарт хугацаанаас 23 хоног хоцроож тайлагнасан, мөн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэж ирүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 "...жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх" 54 дүгээр зүйлийн 54.5.Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна: 54.5.5 "нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага өгөх.

2.Тайлант онд 132,250.0 мянган төгрөгийн худалдан авалтад тендер зарлаагүй, 182,040.0 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг гэрээнд заасан хугацаанд хүлээж аваагүй, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, гэрээг дүгнэж, акт үйлдээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "Босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ", 49 дүгээр зүйлийн 49.2-т "Тендерийн хавтаст хэрэгт гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичиг" байна гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бэлтгэн нийлүүлэгчтэй хийсэн гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих, гэрээ дүгнэсэн акт үйлдэж, худалдан авалтын материалыг иж бүрэн бүрдүүлэх, босго үнээс давсан төсөвт өртөгтэй бараа үйлчилгээнд нээлттэй тендер зарлах, зөрчлийг давтан гаргахгүй байх, албан шаардлага өгөх.

3. Жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 16 харилцагчийн 249,591.5 мянган төгрөгийн авлага, өглөгийн үлдэгдэлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.6-т "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, эрх үүрэг ба батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай үүссэн авлага, өглөгийн тооцоог тооцоо нийлсэн актаар бүрэн баталгаажуулах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, албан шаардлага өгөх.

### **4.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Бүртгэл тайлагналтай холбоотой асуудал**

##### **1.1 Илрүүлэлт:**

ЭМС-ын 2021 оны А/122, А/188, А/422, А/495, А/500, А/798 дугаар тушаалуудаар нэг бүрийн үнэ, тоо хэмжээ зөрүүтэй нийт 146,506.6 мянган төгрөгийн дутуу бараа материалыг санхүүгийн тайланд бүртгэсэн, ЭМС-ын 2021 оны 177 дугаар тушаалаар 688,369.4 мянган төгрөгийн хүчилтөрөгчийн хийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг хүлээн авч, ЭМЯ-тай тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан боловч үндсэн хөрөнгөнд бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага, бүх орлогыг заавал бүртгэнэ" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### **1.2 Өгсөн зөвлөмж:**

Дээд шатны байгууллагаас хуваарилсан хөрөнгө, бараа материалыг холбогдох анхан шатны баримт, тушаал шийдвэртэй тулган дансанд зөв дүнгээр бүртгэх.

#### **2. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал**

##### **2.1 Илрүүлэлт:**

Тайлант онд ЭМС-ын 2021 оны эрх шилжүүлэх А/02 дугаар тушаалаар ХӨСҮТ-д 3,957,994.0 мянган төгрөгийг коронавирусын урвалж оношлуур, дагалдах хэрэгсэл худалдан авах зориулалтаар олгосноос 88,809.6 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-т "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй, ЭМС-ын 2021 оны А/02 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

##### **2.2 Өгсөн зөвлөмж:**

Нэмэлт санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулах, нэмэлт төсвийн тайлан бэлтгэж, зарцуулалтыг үнэн зөв, тодорхой тайлагнах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх.

#### **3. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

##### **3.1 Илрүүлэлт:**

Батлагдсан төсвөөс хангамж бараа материалыг 96,258.4 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 367,851.3 мянга, урсгал засварын зардлыг 274,365.7 мянга нийт 738,475.4 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

##### **3.2 Өгсөн зөвлөмж:**

Төсвийг үнэн зөв, бодитой төлөвлөж, төсвийн хэтрэлт үүсгэхгүй байх.

#### **4. Анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой асуудал**

##### **4.1 Илрүүлэлт:**

Байгууллагын жижиг мөнгөн сангаас анхан шатны баримтгүй 500.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн зүйлийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### 4.2 Өгсөн зөвлөмж:

Авлагын тооцоог холбогдох ажилчидтай хийж, барагдуулах.

### **5. Дотоод хяналттай холбоотой асуудал**

#### 5.1 Илрүүлэлт:

ХӨСҮТ-ийн Ковид 19 цар тахлын улмаас хэвтэн эмчлүүлсэн иргэдийн статистик мэдээнээс нэг хүнд ногдох дундаж зардлыг тооцоолоогүй байна. Мөн хэвтэн эмчлүүлэгсдээс 23 иргэний өвчний түүхээс түүвэрлэн шалгахад статистик мэдээний зардлын дүнгээс зөрүүтэй, шинжилгээний төлбөрийг бусад зардалд ямар дүнгээр тооцож оруулсан нь тодорхойгүй байна.

Энэ нь Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 5 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын "нэхэмжлэхийн хяналтын шалгуур" гэж заасантай нийцээгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

#### 5.2 Өгсөн зөвлөмж:

Хэвтэн эмчлүүлэгсдийн нэг хүнд ногдох дундаж зардлыг үнэн зөв бэлтгэн гаргаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаарлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Хуулийн байгууллагад		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар																
1	ХӨСҮТ	АХГ-2022/373/Н А-СТА-ТШЗ	ЭМС-ын А/122, А/188, А/422, А/495, А/500, А/798 дугаар тушаалуудаар нэг бүрийн үнэ, тоо хэмжээ зөрүүтэйгээс нийт 146,506.6 мянган төгрөгөөр дутуу бараа материалын тайланд бүртгэсэн байна.	Дээд шатны байгууллагаас хуваарилсан хөрөнгө, бараа материалыг холбогдох анхан шатны баримт, тушаал шийдвэртэй тулган дансанд зөв дүнгээр бүртгэх.	1	146,506.6								1	834,876.0	
	ХӨСҮТ	АХГ-2022/373/Н А-СТА-ТШЗ	ЭМС-ын 2021 оны 177 дугаар тушаалаар 688,369.4 мянган төгрөгийн хүчилтөрөгчийн хийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг ХӨСҮТ-д хүлээн авч, ЭМЯ-тай тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан боловч үндсэн хөрөнгөнд бүртгээгүй.			688,369.4										
2	ХӨСҮТ	АХГ-2022/373/Н А-СТА-ТШЗ	Тайлант онд ЭМС-ын 202 эрх шилжүүлэх А/02 дугаар тушаалаар ХӨСҮТ-д 3,957,994.0 мянган төгрөгийг коронавирусын урвалж оношлуур, дагалдах хэрэгсэл худалдан авах зориулалтаар олгосноос 88,809.6 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.	Нэмэлт санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулах, нэмэлт төсвийн тайлан бэлтгэж, зарцуулалтыг үнэн зөв, тодорхой тайлагнах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх.	1	88,809.6								1	88,809.6	

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн аудитын тайлан

3	ХӨСҮТ	АХГ- 2022/373/Н А-СТА-ТШЗ	Лайфтроник ХХК-тай хийсэн эм, эмийн хэрэгслийн худалдан авах гэрээгээр 182,040.0 мянган төгрөгийн бараа материалыг хүлээж аваагүй, Мөнхийн тун ХХК - аас худалдаж авсан 132,250.0 мянган төгрөгийн эм, эмийн хэрэгсэлд тендер зарлаагүй зэрэг нь худалдан авах ажиллагааны гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьдаггүй, гэрээ дүгнэсэн акт байхгүй байгаатай холбоотой байна.	Бэлтгэн нийлүүлэгчтэй хийсэн гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих, гэрээ дүгнэсэн акт үйлдэж, худалдан авалтын материалыг иж бүрэн бүрдүүлэх, босго үнээс давсан төсөвт өртөгтэй бараа үйлчилгээнд нээлттэй тендер зарлах, зөрчлийг давтан гаргахгүй байх,	1	314,290.0					1	314,290.0		
4	ХӨСҮТ	АХГ- 2022/373/Н А-СТА-ТШЗ	Батлагдсан төсвөөс хангамж бараа материалыг 96,258.4 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 367,851.3 мянга, урсгал засварын зардлыг 274,365.7 мянга нийт 738,475.4 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан байна.	Төсвийг бодитой төлөвлөж, төсвийн хэтрэлт үүсгэхгүй байх.	1	738,475.4							1	738,475.4
5	ХӨСҮТ	АХГ- 2022/373/Н А-СТА-ТШЗ	Байгууллагын жижиг мөнгөн сангаас анхан шатны баримтгүй 500.1 мянган төгрөгийг зарцуулсан.	Авлагын тооцоог холбогдох ажилчидтай хийж, барагдуулах.	1	500.1							1	500.1
6	ХӨСҮТ	АХГ- 2022/373/Н А-СТА-ТШЗ	Жилийн эцсээр авлага өглөгийн үлдэгдэлтэй гарсан 16 харилцагчийн 249,591.5 мянган төгрөгийн тооцоог тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	Бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай үүссэн авлага өглөгийн тооцоог тооцоо нийлсэн актаар бүрэн баталгаажуулах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх,	1	249,591.5					1	249,591.5		



Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн аудитын тайлан

7	ХӨСҮТ	АХГ-2022/373/Н А-СТА-ТШЗ	ХӨСҮТ-ийн Ковид 19 цар тахлын улмаас хэвтэн эмчлүүлсэн иргэдийн статистик мэдээнээс нэг хүнд ногдох дундаж зардлыг тооцоолоогүй байна. Мөн хэвтэн эмчлүүлэгсдээс 23 иргэний өвчний түүхээс түүвэрлэн шалгахад статистик мэдээний зардлын дүнгээс зөрүүтэй, шинжилгээний төлбөрийг бусад зардалд ямар дүнгээр тооцож оруулсан нь тодорхойгүй байна.	Хэвтэн эмчлүүлэгсдийн нэг хүнд ногдох дундаж зардлыг үнэн зөв оновчтой, бэлтгэн гаргаж байх.	1	-								1	-	
8	ХӨСҮТ	АХГ-2022/373/Н А-СТА-ТШЗ	Жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанаас 23 хоног хоцорч тайлагнасан. Мөн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэж ирүүлээгүй байна.	Тайланг иж бүрэн бэлтгэн, хуулийн хугацаандаа тайлагнаж байх.	1	-							1	-		
Дүн					8	2,226,542.6	-	-			2	563.881.5	1	-	5	1,662,661.1
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал																
9	ХӨСҮТ	АХГ-2022/373/Н А-СТА-ТШЗ	ЭМС-ын 2021 оны 5 дугаар сарын 12-ны А/307 дугаар тушаалын дагуу 54,720.0 мянган төгрөгийн Starmag 96 ргоргер С plate ялгах оношлуурыг ХӨСҮТ хүлээн авч, ЭМЯ-тай тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан хэдий ч бүртгэл тайланд тусгаагүй. Мөн уг оношлуурыг зарцуулсан тухай анхан шатны баримтыг ирүүлээгүй.	Хуулийн байгууллагад шилжүүлэх	1	54,720.0								1	54,720.0	
			ЭМС-ын тайлант оны А/358, А/495 дугаар тушаалуудаар 46,376.0 мянган төгрөгийн эмийг хуваарилж, ЭМЯ-тай тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан боловч бараа материалын дансанд орлогоор бүртгээгүй.		1	46,376.0						1	46,376.0			

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн аудитын тайлан

10	ХӨСҮТ	АХГ- 2022/373/Н А-СТА-ТШЗ	Бараа материал болон ажил үйлчилгээний худалдан авалтыг журнал болон цахим төлбөрийн баримтын системтэй тулган шалгахад 54 байгууллагын 1,307,491.7 мянган төгрөгийг ажил гүйлгээг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулж аваагүй байв.	Төлбөрийн цахим баримтыг бэлтгэн нийлүүлэгчээс бүрэн гаргуулах авах, татварын цахим системээр худалдан авалтыг тухай бүрэн хянаж ажиллах талаар албан шаардлага өгөх	1	1,307,491.7					1	1,307,491.7				
11	ХӨСҮТ	АХГ- 2022/373/Н А-СТА-ТШЗ	Үндсэн хөрөнгийн тооллогыг тооллогын комиссоор бүрэн баталгаажуулаагүй, илтгэх хуудас бэлтгээгүй байна.	Үндсэн хөрөнгийн тооллогын үр дүнг комиссын хурлаар хэлэлцэн баталгаажуулж, тооллогын илтгэх хуудас бэлтгэж байх.	1	-								1	-	
12	ХӨСҮТ	АХГ- 2022/373/Н А-СТА-ТШЗ	Халдварт өвчин судлалын үндэсний төв нь 2021 онд нийт 98,784,080.7 мянган төгрөгийн 1077 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 3,831,947.3 мянган төгрөгийн 25 гүйлгээг ил тод байршуулаагүй, 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, мэдээлвэл зохих 52 тендерээс 20,975,019.6 мянган төгрөгийн 38 тендерийг мэдээлээгүй байна.	Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчлийг тайлант онд давтан гаргасан тул хариуцлага тооцох албан шаардлага өгөх.	1	24,807,466.9					1	24,807,466.9				
Дүн					4	26,216,054.6	-	-	1	101,096.0	1	1,307,491.7	1	24,807,466.9	1	-
Нийт дүн					12	28,442,597.2	-	-	1	101,096.0	3	1,871,373.2	2	24,807,466.9	6	1,662,661.1



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 537/А0150054  
АХТ-2022/379/НА-СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 132,250,000.00 төгрөгийн худалдан авалтад тендер зарлаагүй, 182,040,000.00 төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг гэрээний хугацаанд хүлээж аваагүй, худалдан авах ажиллагааны гэрээний хэрэгжилтэд хяналт тавьдаггүй, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.2 “босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ”, мөн тус хуулийн 49.2.1 “Гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичиг” тендерийн хавтаст хэрэгт байна” гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, гэрээ дүгнэсэн акт үйлдэж, тендерийн хавтаст хэргийг иж бүрэн бүрдүүлэх босго үнээс давсан төсөвт өртөгтэй бараа үйлчилгээнд нээлттэй тендер зарлах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал Ц.Билэгтсайхан, Стратеги төлөвлөлт, гадаад харилцаа эрхэлсэн дэд захирал Д.Баярсайхан нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
НЬЮ ЭСТИМЭЙТОР АУДИТ ХХ-ИЙН  
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Г.ГҮНЖИДМАА  
Ж.ҮХЭРТАР

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

\\0.10.10.20\Bichig\_Khereg\Alban Shaardloga\2022\0315 Auditin 2 Gazar-215.Docx

0001081410



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 536/АД150054  
АХГ-2022/373/НА-СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуульд заасан цаглаварт хугацаанаас 23 хоног хоцроож ирүүлсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэж ирүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх"; 54 дүгээр зүйлийн 54.5. Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна: 54.5.5 "нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.2-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд тайлагнан, аудитын байгууллагад хүргүүлэх албан үүргээ биелүүлээгүй, нягтлан бодогч Б.Пагамдуламд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг захирал Ц.Билэгтсайханд даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
НЬО ЭСТИМЭЙТОР АУДИТ ХХК-ИЙН  
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Г.ГҮНЖИДМАА

Ж.ҮХЭРТАР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-204230

9006109  
9019120396  
\\0.10.10.20\Bichig\_Kheren\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Газар-217.Docx

0001081412





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 535/АД-150054  
АХГ-2022/373/НА-СТА-ТШБ

Улаанбаатар хот

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын 3,831,947,313.11 төгрөгийн 25 гүйлгээг ил тод байршуулаагүй, 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, мэдээлбэл зохих 52 тендерээс 20,975,519,686.00 төгрөгийн 38 тендерийг мэдээлээгүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”; 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”; 6 дугаар зүйлийн 6.4.3.тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан”-г долоо хоногийн дотор мэдээлнэ” 6.4.4. “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”; 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.2-т заасныг үндэслэнэ гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх оны аудитаар өгсөн шилэн дансны мэдээллийг хугацаанд нь, иж бүрэн мэдээлэх албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй нягтлан бодогч Б.Пагамдуламд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг захирал Ц.Билэгтсайханд даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
НЬЮ ЭСТИМЭЙТОР АУДИТ ХХК-ИЙН  
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Г.ГҮНЖИДМАА  
Ж.ҮХЭРТАР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

110.10.10.20\Bichig\_Khereg\Alban\_Shaardlaga\2022\0315\_Auditin\_2\_Gazar-218.Docx

0001081414



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 09 дугаар сарын 15 № 534/А0150054  
АХГ-2022/373/НА-СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 54 харилцагч байгууллагын 1,307,491,706.90 төгрөгийн худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэсэн заалттай гэсэн заалттай нийцээгүй, тохиолдсон байх ба эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авалтын ажил гүйлгээний цахим төлбөрийн баримтыг бэлтгэн нийлүүлэгчээс бүрэн гаргуулж авах, татварын цахим системээр худалдан авалтыг тухай бүр хянаж ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал Ц.Билэгтсайхан, нягтлан бодогч Б.Пагамдулам нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
НЬУ ЭСТИМЭЙТОР АУДИТ ХХК-ийн  
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Т.ГҮНЖИДМАА

Ж.ҮХЭРТАР

0001021416



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 530/A0150054  
АХГ-2022/373/НА-СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жилийн эцсийн тайлангаар авлага, өглөгийн үлдэгдэлтэй 16 харилцагчийн 249,591,482.81 төгрөгийн тооцоог тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.6 “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, өглөг, авлагын үлдэгдэлтэй харилцагчидтай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулж байх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал Ц.Билэгтсайхан, нягтлан бодогч Б.Пагамдулам нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
НЬЮ ЭСТИМЭЙТОР АУДИТ ХХК-ИЙН  
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Г.ГҮНЖИДМАА

Ж.ҮХЭРТАР

0001081498

## ТЭМДЭГЛЭЛ

A series of 32 horizontal dotted lines for writing a conclusion.